

Монгол хэлээр

2023-2024

STUDY IN JAPAN

////// ГАРЫН АВЛАГА ////

www.studyinjapan.go.jp



Independent Administrative Institution
Japan Student Services
Organization

 **STUDY in JAPAN**

ЯПОНЫ ТАЛААРХ 10 БАРИМТ

Японд суралцаж буй гадаад оюутны тоо

Ойролцоогоор

230,000 хүн



Ази	93.0%	Хойд Америк	0.9%	Ойрхи Дорнод	0.5%
Европ	3.7%	Америк	1.0%	Латин Америк	0.8%
				Номхон Далайн Орнууд	0.2%

Японоос төрсөн Нобелийн шагналтнууд

28 хүн

НҮБ-д оруулах хөрөнгө

3 байр

Үндэсний нийт бүтээгдэхүүн

3 байр

QS Дэлхийн Их Сургуулиудын үзүүлэлт 2023 ТОП 1000-д орсон сургуулийн тоо

38 их сургууль

Үйлдвэрлэлд ашиглагдаж буй роботын тоо

2 байр

Дэлхийн өвийн тоо

25 газар

Дэлхийн энх тайвны индекс

10 байр

Амьдрахад таатай хот/Сэтгэл татам хотын үзүүлэлт ТОП 10-т орсон хотын тоо: 1 хот (3-р байр)

1 Хот (3 байр)

Автомашин экспортын тоо хэмжээ

2 байр

Яагаад Японд сурах ёстой вэ?

Изумокагура © iku



Японд цайны урлаг, кабуки жүжиг, тулааны урлаг зэрэг уламжлалт соёл болон манга, анимэ зэрэг орчин үеийн соёл зэрэгцэн оршдог.

Өвлийн халуун рашаантай газар. (Гинзан халуун рашаан, Обаназава хот) ©Koichi_Hayakawa



Далай болон уулсаар хүрээлэгдсэн Японд хавар, зун, намар, өвлийн улиралд өөр өөр байгалийн үзэмжийг тольдох боломжтой.

Соёл



Яхико сүмийн сүмо ордон, ©Yahiko тосгон

Байгаль



Фүжи уул болон Кавагүчи нуурын эрэг дээрх намрын нэвчис ©Koichi_Hayakawa

Шинжлэх ухаан & Технологи



Наганожикан ©yurani

Хоол



Сүши



Шинкансэн

Дэлхийн жишигт нийцсэн шинжлэх ухаан, технологи нь Японы дэвшилтэт анагаахын салбар болон тав тухтай амьдралын хэв маягийг бий болгож байдаг. Японы засгийн газар шинжлэх ухаан, технологийн салбарын цаашдын өсөлтөд ихээхэн анхаарлаа хандуулж байгаа бөгөөд Японд үйлдвэрлэсэн супер компьютерууд дэлхийн шилдгүүдийн тоонд орсоор байна.


ЮНЕСКО-гийн биет бус соёлын өвд бүртгэгдсэн япон хоол нь улирлын чанартай орц найрлагыг шингээсэн өнгөлөг, эрүүл хоол гэдгээрээ дэлхий дахины анхаарлыг татдаг.



Такояки

Эх сурвалж: ● Хүүхдийн ГХЯ, "Орчлон дэлхийн элдэв сонин" (<https://www.mofa.go.jp/mofaj/kids/ranking/index.html>) ● Conde Nast Traveler (Readers' Choice Awards 2022) ● Global Peace Index 2022 ● UNESCO World Heritage List (<https://whc.unesco.org/en/list/>) ● 2022 оны Олон улсын оюутны элсэлтийн байдлын судалгаа (JASSO) ● Японы роботын аж үйлдвэрийн холбоо (<https://www.jara.jp/data/index.html>)

Япон дахь дээд боловсрол



- Японы дээд боловсрол нь бага сургуульд 6 жил, дунд сургуульд 3 жил, ахлах сургуульд 3 жил (нийт 12 жил) суралцсаны дараа эхэлдэг.
- Японы их сургуульд элсэх хүсэлтэй сурагчид **албан ёсны 12 жилийн боловсрол эзэмшсэн байх ёстой.**
- Ерөнхий боловсролын сургуульд 12-оос бага жил суралцсан бол их сургуульд элсэхээсээ өмнө 1 эсвэл 2 жилийн бэлтгэл курст суралцах ёстой.

Японд суралцах 7 алхам

START Их сургууль болон мэргэжлийн сургуульд үндсэн оюутнаар элсэх үед

- АЛХАМ 1 Мэдээлэл цуглуулах**
 - ▶ Шаардлагатай хэлний мэдлэг болон зардлаа тооцоолох.
- АЛХАМ 2 Сургууль сонгох**
 - < Элсэхээс 12 сарын өмнө >
 - ▶ Танилцуулга болон өргөдлийн маягтыг илгээх.
- АЛХАМ 3 Шалгалт өгөх**
 - ▶ Шаардлагатай шалгалтуудыг өгсөн байх. (JLPT, EJU, TOEFL, IELTS, SAT, IB гэх мэт)
- АЛХАМ 4 Өргөдөл гаргах**
 - < Элсэхээс 6-9 сарын өмнө >
 - ▶ Суралцах сургууль руу шаардлагатай бичиг баримтыг илгээх.
 - ▶ Шалгалтын хураамж төлөх.
- АЛХАМ 5 Шалгалт өгөх**
 - ▶ Бичиг баримтын шалгалтад тэнцсэний дараа ярилцлагад орж, элсэлтийн шалгалт өгнө.
- АЛХАМ 6 Элсэх үйл явц**
 - ▶ Суралцах зөвшөөрөл авах.
 - ▶ Сургалтын төлбөр төлөх.
- АЛХАМ 7 Очих бэлтгэл**
 - ▶ Виз мэдүүлэх.
 - ▶ Нислэгийн тийз болон даатгалд хамрагдах.

GOAL

EJU-ийн талаар



Examination for Japanese University Admission for International Students (EJU)

Японы их дээд сургуульд элсэн суралцах хүсэлтэй хүмүүсийн япон хэлний мэдлэг болон үндсэн мэдлэгийг тогтоох шалгалт юм.

- ★ Японы их дээд сургуулиудын 60 гаруй хувь нь (Улсын их дээд сургуулийн 90 гаруй хувь)
- ★ Дүнгийн хүчинтэй хугацаа 2 жил.
- ★ EJU-д өндөр оноо авсан оюутнуудад сургалтын урамшууллын тэтгэмж олгоно. (7-р хуудас)
- ★ Шалгалтыг хэдэн ч удаа өгөх боломжтой.

Шалгалт авах хугацаа:

Жилд 2 удаа зохион байгуулагддаг. (6 сар болон 11 сар)

Шалгалт авах байршил:

Японд болон гадаадын 14 улс, бүс нутгуудад зохион байгуулагддаг.

EJU
<https://www.jasso.go.jp/ryugaku/eju/index.html>



Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал

Сургалтын төлбөр

● Их сургуулийн эхний жилийн сургалтын төлбөрийн тооцоолол



※ Анагаах ухаан, шүд, эм зүйгээс бусад.

※ Эхний жилд элсэлтийн хураамж гэх мэт тусдаа төлбөр шаардагдана.


Эх сурвалж:

● Боловсролын яамны хувийн их, дээд сургуульд 2021 онд элсэн суралцаж буй оюутнуудын төлбөр гэх мэт судалгааны үр дүнгийн тухай мэдээлэл. (https://www.mext.go.jp/a_menu/koutoushinkou/07021403/1412031_00004.htm)

Амьжиргааны зардал

● Амьжиргааны зардлын тооцоолол

Том хотуудын хувьд амьжиргааны зардал илүү өндөр
Жишээ нь: Токио: 108,000 иен



Эх сурвалж: Засгийн газрын статистикийн нэгдсэн лавлах. Жижиглэнгийн үнийн судалгаа (Токио хот 2023 оны 3 сар)

Дотуур байрны төлбөрийг Токиогийн Япон хэлний боловсролын төвийн оюутны дотуур байр, 20 м.кв хувийн сууцны хувьд тооцолсон болно.

Эх сурвалж: "Хувийн зардлаар сурч буй гадаад оюутнуудын аж байдлын судалгаа", 2021 он (JASSO)

Суралцах хугацаан дахь цагийн ажил

"Сурах" гэсэн оршин суух статустай хүмүүс ойролцоох Гадаадын Иргэн, Харьяатын Газарт "Статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл"-н хүсэлт өгснөөр долоо хоногт 28 хүртэл цагаар ажиллах эрхтэй болдог.

❗ **"Японд суралцангаа мөнгө хийж болно" гэж тодотгосон зуучлагч байгууллагуудаас болгоомжлох хэрэгтэй.** ❗

1 цагт 3,000 иений цалин авах боломжтой.



Цагийн ажлын хөлс нэг цагт 1,000 иен орчим байдаг.

Гадаад оюутнууд цагийн ажил хийгээд сард 300,000 иен олдог.



Цагийн ажил хийгээд сард 59,000 орчим иен олдог.

Тэтгэлэг ба санхүүгийн тусламж

Тэтгэлэг
<https://www.studyinjapan.go.jp/ja/planning/about-scholarship/>



Арга 1 Засгийн газрын тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргах

*Түвшнээс хамаарч хэмжээ нь өөр өөр байдаг. **Япон хэлний сургуулийн сурагчдад зориулсан дүн

	MEXT Тэтгэлэг	Сургалтын урамшууллын тэтгэмж	Гадаадад суралцахад дэмжлэг үзүүлэх систем
Сарын тэтгэлгийн хэмжээ	117,000 иенээс*	48,000 иен эсвэл 30,000 иен**	80,000 иен
Сургалтын төлбөрөөс чөлөөлөх	✓		
Үнэгүй нислэгийн тийз	✓		
Үнэгүй бэлтгэл хичээл	✓		
Тэтгэлгийн хугацаа	Суралцаж буй хугацаанд	1 жил болон 6 сар	Хөтөлбөрт хамрагдаж буй хугацаанд
Зорилтот оюутнууд	Магистр, Бакалавр, Техникийн коллеж, Мэргэжлийн сургууль (коллеж), Япон хэл соёл судлаач болон Багшийн мэргэжил дээшлүүлэх курсын оюутнууд	Магистр, Бакалавр, Богино хугацааны дээд сургууль, Техникийн коллеж, Мэргэжлийн сургууль (коллеж), Япон хэлний сургуулийн оюутнууд	Нэг жилээс доош хугацаагаар суралцах, Магистр, Техникийн коллеж, Мэргэжлийн сургууль (коллеж)-ийн оюутнууд
Сурлагын шалгуур	✓	✓	✓
Өрхийн төсөв		✓	✓
Шалгаруулах арга	Бичиг баримтын шалгаруулалт, бичгийн шалгалт, ярилцлага	Сургуулиасаа шалтгаална	Бичиг баримтын шалгаруулалт
Сонгогдох хүний тоо	Тодорхойгүй	Ойролцоогоор 7000 орчим хүн	Ойролцоогоор 5000 орчим хүн

Холбоо барих болон бүртгүүлэх бол...

Тухайн улс дахь Японы ЭСЯ/одоо сурч буй сургууль

Сурахаар төлөвлөж буй сургууль

Одоо сурч буй сургууль

Арга 2

Орон нутгийн засаг захиргаа болон хувийн байгууллагуудын тэтгэлэгт бүртгүүлэх.

- Сургуульдаа элсэж орсны дараа бүртгүүлнэ.
- Иргэншил, суралцах сургууль, суралцах чиглэлийг ихэнхдээ заасан байдаг.
- Жилд хэдэн ч хүн шалгаруулж болно. Та доорх сайтаас хайлт хийх боломжтой.

Орон нутгийн засаг захиргаа, хувийн байгууллагуудын тэтгэлэг
<https://www.studyinjapan.go.jp/ja/planning/about-scholarship/>



Холбоо барих болон бүртгүүлэх бол...

Гадаадад суралцахаар төлөвлөж буй сургууль/байгууллага

Арга 3

Сургуулийн тусгай тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргах
*Сургалтын төлбөрөөс хөнгөлөх болон чөлөөлөх тогтолцоонд хамрагдах.

Х Их сургуулийн хувьд...

Сургалтын төлбөрөөс чөлөөлөх (50% болон 100%)

Зорилтот бүлэг.....

Санхүүгийн боломжгүйн улмаас сургалтын төлбөрөө төлөхөд хүндрэлтэй байгаа болон сурлагын амжилт сайтай оюутнууд.

Y Их сургуулийн хувьд...

Сард 82,000 иений тэтгэлэг (4 жил)

Зорилтот бүлэг.....

Элсэлтийн шалгалтад сайн дүн үзүүлсэн оюутнууд


Холбоо барих болон бүртгүүлэх бол...

Суралцахаар төлөвлөж буй сургууль

Японд ажиллах

Суралцахаас эхлээд ажиллах хүртэл

"Сурах" статусаас ажиллах статус руу өөрчлөлт хийлгэх хүсэлтэд



Гадаад оюутнуудын ажилд орсон мэргэжлүүд (Эхний 10 байр)

Байр	Ажлын агуулга
1	Орчуулагч, хэлмэрч
2	Төлөвлөлтийн ажил (маркетингийн судалгаа)
3	Гадаад худалдаа
4	Захиргаа (хувираа бизнес эрхлэгчээс бусад)
5	Мэдээлэл боловсруулах/харилцаа холбооны технологи
6	Худалдаа, борлуулалт
7	Төлөвлөлтийн ажил (олон нийттэй харилцах/зар сурталчилгаа)
8	Технологийн хөгжил
9	Нягтлан бодох бүртгэлийн ажил
10	Асаргааны ажил

Эх сурвалж: "2021 оны Япон дахь гадаад оюутнуудын хөдөлмөр эрхлэлтийн байдал. (Японы цагаачлалын алба)

Ажилд орохын тулд

Японы ажилд орох үйл явц нь ихээхэн онцлогтой учир ажилд орохыг хүсэж буй оюутнууд эртнээс бэлдэж эхлэх хэрэгтэй. Доорх вебсайт-аас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

Гадаад оюутнуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх гарын авлага (JASSO)
https://www.jasso.go.jp/ryugaku/after_study_j/job/guide.html

Гадаадын өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийн идэвхтэй оролцоог дэмжих портал (JETRO)
<https://www.jetro.go.jp/hrportal/>



Ярилцлага



Шаардлагатай хүний нөөц болохын тулд япон хэл, японы байгууллагын соёлыг эзэмшицгээе!

Austin

2012 онд Японд ирээд бэлтгэл сургуулиа дүүргээд Токиогийн их сургуульд улс төр судлалын чиглэлээр элсэн орсон. Одоо чөлөөт програмистаар ажилладаг. Японы их дээд сургуулиуд мэргэжлийн чиглэлээс хамааран эрх чөлөөтэй байдал, дадлага хийх зэрэг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох боломжийг олгодог орооно. Мөн түүнчлэн төгсөгчдийг ажилд авах шинэ тогтолцоо бий болж, өндөр хөгжилтэй орнуудын дунд анхны карьераа тодорхойлоход хамгийн хялбар хэмээн тооцогдож байна. Японд амжилтад хүрэхийн тулд япончуудтай уусахаас илүүтэй гадаад хүний хувьд өөрийн өвөрмөц давуу талаа ашиглах хэрэгтэй. Японд суралцаж ажилласнаар олж авсан хэлний мэдлэг, өвөрмөц соёлын талаарх ойлголт нь юугаар ч орлуулшгүй давуу тал юм. Даяариллын эрин үед дэлхийн хаана ч байсан ажиллаж чадах эрэлттэй ажилтан болохыг хүсэж байвал Японд сурч, ажиллахыг зөвлөж байна.

Ярилцлага




Японы барилгын инженерийн технологийг Руанда руу түгээхийг хүсэж байна!

Rumanzi Hypolite

Майзуру үндэсний технологийн коллеж (ярилцлага хийх үед)

Манай улс дэд бүтцээ сайжруулахыг хүсдэг ч чадварлаг архитектор, инженерүүд дутмаг байдаг. Тиймээс боловсрол, технологийн түвшин өндөр Япон улсад суралцаж, ирээдүйд эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулахыг зорьж ирсэн. Японд амьдрах үед ямар нэгэн асуудал, бэрхшээл тулгарахад эргэн тойронд туслахад бэлэн хүмүүс байдаг нь талархууштай. Одоо технологийн коллежид барилгын инженер мэргэжлээр суралцаж байгаа ч цаашид их сургуульд илжж суралцах бодолтой байгаа. Боломжтой бол магистарт мөн сурмаар байна. Миний мөрөөдөл бол эх орондоо барилгын компани байгуулж, Японд сурсан ур чадвар, японы соёлыг залуу хойч үедээ сургах юм.



Тэтгэлэгт хамрагдах нь хичээлдээ анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгодог.

Ioannis Gkolfopoulos

Токиогийн Технологийн дээд сургууль, Барилгын инженерийн магистр (ярилцлага хийх үед)

Японд суралцах хугацаандаа санхүүгийн асуудлаас ангиуд байх нь судалгаандаа анхаарлаа төвлөрүүлэхэд маш чухал гэж үзсэн учраас Японы засгийн газрын тэтгэлэгт хамрагдахаар шийдсэн. Японы их дээд сургуулиуд оюутнуудаа маш сайн дэмжлэг үзүүлж, заавар зөвлөгөө өгдөг нь сайхан сэтгэгдэл төрүүлсэн. Нөгөөтэйгүүр, анагалал ихтэй үеийн замын түгжрэлийг хараад гайхсан. Япон бол уламжлал, шинэ технологи зэрэгцэн оршдог өвөрмөц орон юм. Барууныхны хувьд соёлын асар их цочролд орох магадгүй болохоор япон хэл, соёлын талаар суралцах нь чухал. Японы засгийн газрын тэтгэлэг нь оюутны амьдралыг жигдрүүлэх баталгаа тул та ч гэсэн оролдоод үзээрэй.

Японы их сургуулийн амьдрал



Японд суралцах цаг хугацаагаа сэтгэл хангалуун өнгөрүүлцгээе!

Kiaulakite Paulina

Очаномизү их сургууль Амьдрах ухааны факультетийн сэтгэл судлалын тэнхим (ярилцлага хийх үед)

Японд суралцах хүсэл эрмэлзлийг минь төрүүлсэн зүйл бол дунд сургуульд байхдаа Японд анх ирсэн явдал юм. Би Токиогийн соёлд татагдаж энд суралцах хүсэлтэй байгаагаа мэдэрсэн. Засгийн газрын тэтгэлэгтэй гадаад оюутны шалгалтад тэнцэж, Токиогийн Гадаад судлалын их сургуульд нэг жил япон хэл сураад Очаномизү их сургуулийн Амьдрах ухааны факультетийн сэтгэл судлалын тэнхимд элсэн орсон. Очаномизү их сургууль нь харьцангуй жижиг улсын их сургууль тул гадаад оюутнуудыг япон оюутнуудаас ялгаж үздэггүй. Хичээлийн хөтөлбөр, хичээлийн агуулга нь Японы их дээд сургуулийн сэтгэл судлалын тэнхимийн оюутнуудынхтай адилхан. Тиймээс даалгавар, шалгалт нь заримдаа хэцүү мэт санагдаж болох ч сурах зүйл маш их байгааг илтгэж байдаг. Мөн япон найзуудтай болж, тэдэнтэй хамт чөлөөт цагаа өнгөрөөж чаддаг болохоор оюутны амьдралдаа сэтгэл хангалуун байдаг.



↑ Завсарлагааны үеэр болдог бие даан суралцах үйл ажиллагаа болон хэлний кафены зураг. Бид бүгд бие биедээ дотно байдаг.
 ← Киобаши дахь аялал жуулчлалын газарт авсан зураг. Японы соёлоор хүрээлэгдсэн байгаа биз!

Ердийн өдрийн хуваарь

8:00 Босох цаг

Нүүрээ угаагаад өглөөний цайгаа ууна.

10:00 Сургууль руу явна.

Их сургуультайгаа ойрхон амьдардаг болохоор ирж очих хугацаа бага.

10:30 - 12:10 Өглөөний хичээл

Найзуудтайгаа цуг хичээлдээ суудаг.

12:10 - 13:20 Өдрийн цай

Найзуудтайгаа цайны газарт өдрийн хоол идэж, номын санд хичээлээ хийж, ангидаа ярилцдаг.

13:20 - 16:30 Өдрийн хичээл

Багшийн яриаг анхааралтай сонсож, тэмдэглэл хөтөлдөг.

16:30 - 18:30 Чөлөөт цаг

Хичээлийн дараа япон найзуудтайгаа цагийг өнгөрүүлдэг. Их сургуультай ойрхон болохоор ихэвчлэн Икэбүкуро руу явдаг. Мөн хамтдаа оройн хоол идэж, караокэ ордог.

Японд суралцах тухай мэдээллийн сайт

Японд суралцах тухай мэдээллийн сайт нь Японд суралцахад хэрхэн бэлдэх, Японы сургууль болон амьдралын талаарх мэдээлэл, тэтгэлэг, Японд суралцахад шаардлагатай бусад мэдээллийг агуулсан болно. Мөн та өөрийн сонирхолд тохирсон сургуулийг мэргэжил, суралцах хэл, сургуулийн байршлаар хайж болно. Японд суралцах сонирхолтой эсвэл Японд суралцах сургууль хайж байгаа, эсвэл гадаадад сурах тал дээр эргэлзэж байгаа, суралцах улсаа хайж байгаа бол манай Японд суралцах мэдээллийн сайтаар заавал зочлоорой!



Японд суралцах тухай мэдээллийн сайт
<https://www.studyinjapan.go.jp/ja/>



Японд суралцах тухай мэдээллийн яармаг


Сургуулийн төлөөлөгчтэй шууд ярилцах ховор боломж юм. Жил бүр цахимаар болон танхимаар зохион байгуулдаг. Бид таны оролцоог хүлээж байна! Дэлгэрэнгүй мэдээллийг Японд суралцах тухай мэдээллийн сайтаас авна уу.

Японд суралцах тухай мэдээллийн яармаг
<https://www.studyinjapan.go.jp/ja/other/event/>



JASSO гадаад дахь салбар

JASSO-ийн гадаад дахь таван салбар дээр та биечлэн, утсаар болон цахим шуудангаар зөвлөгөө авч, Японд суралцах тухай лавлахтай танилцаж болно.



Индонез

Summitmas Tower II, 2nd Floor, Jalan Jenderal Sudirman Kav. 61-62, Jakarta 12190 INDONESIA
 Tel : (+62) 21-252-1912
 E-mail : info@jasso.or.id
 Web : <https://www.jasso.or.id/>
 Facebook : <https://www.facebook.com/JASSO.Indonesia>
 Instagram : <https://www.instagram.com/jasso.indonesia/>
 WhatsApp: <https://api.whatsapp.com/send?phone=62212521912>



Тайланд

1016/3, 10F Serm-mit Tower, 159 Asok-Montri Rd., Bangkok 10110 THAILAND
 Tel : (+66)2-661-7057
 E-mail : info@jeic-bangkok.org
 Web : <https://www.jeic-bangkok.org/>
 Facebook : <https://www.facebook.com/JASSO.Thailand>



Вьетнам

4th Floor, CornerStone Building, 16 Phan Chu Trinh, Hoan Kiem, Hanoi, VIETNAM
 Tel : (+84) 24-3710-0226
 E-mail : info@jasso.org.vn
 Web : <https://www.jasso.org.vn>
 Facebook : <https://www.facebook.com/JASSO.Vietnam>



Солонгос

#702 Garden Tower, 84 Yulgok-ro, Jongno-gu, Seoul 03131 Republic of KOREA
 Tel : (+82) 2-765-0141
 E-mail : jasso@jasso.or.kr
 Web : <https://www.jasso.or.kr/>
 Facebook : <https://www.facebook.com/JASSO.Korea>
 Instagram: <https://www.instagram.com/jasso.korea/>



Малайз

A-7-5, Northpoint Offices, Mid Valley City, No. 1, Medan Syed Putra Utara, 59200
 Tel : (+60)3-2287-0812
 E-mail : enquiry@studyinjapan.org.my
 Web : <https://www.studyinjapan.org.my/>
 Facebook : <https://www.facebook.com/JASSO.Malaysia/>

Японд суралцах нь танд үр өгөөжөө өгнө гэдэгт бид чин сэтгэлээсээ найдаж байна.

Японы оюутныг дэмжих байгууллага (JASSO)-н гадаад оюутныг дэмжих төсөл

- Тэтгэлгийн төлбөр
- Япон улсад хувийн зардлаар суралцах хүсэлтэй гадаад иргэдэд зориулсан шалгалт (EJU)
- Гадаадад суралцах тухай мэдээлэл цуглуулах, түгээх
- Япон хэлний боловсрол
- Орон байрны дэмжлэг

[Хянасан, хэвлэсэн]

Засгийн газрын бие даасан агентлаг Японы Оюутныг Дэмжих Байгууллага (JASSO)

Гадаад оюутны асуудал хариуцсан хэлтэс, гадаадад суралцах мэдээллийн тасаг
 〒 135-8630, 2-2-1 Aomi, Koto-ku, Tokyo, Japan
 E-mail : infoja@jasso.go.jp

Independent Administrative Institution
Japan Student Services Organization
 JASSO